

Петр Паулыг хэрхэн хүлээн авсан бэ?



"Хайрт ах Паул маань өгөгдсөн мэргэн ухааныхаа дагуу та нарт бичсэнчлэн бидний Эзэний тэвчээрийг аврал хэмээн тооц.

Түүний бүх захидалд эдгээрийн талаар бичсэн юм.

Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг."

2 Петр 3:15-16

Өмнөх нийтлэлд хүн хэрхэн аврагддагийг бид авч үзсэн. Тухайлбал: Дан итгэлээр үү? Эсвэл итгэл дээрээ үйлс нэмэх ёстой юу? Иаков, Петр, Иохан нарын тунхагласан, хозлуулагсдад зориулсан сайн мэдээний дагуу хүн аврагдахын тулд Есүс Христэд итгэж, тэр итгэлд таарсан сайн үйлсийг хийх ёстой. Итгэл нь тууштай, үр жимс гаргадаг итгэл байх ёстой. Харин Паулын үндэстнүүдэд тунхагласан сайн мэдээний дагуу хүн өөрийн зүтгэлээр биш, Христийн төгс итгэл ба Түүний үйлсээр л аврагдсан. Түүний хийсэнд хүн юу ч нэмж чадахгүй. Үүнд итгэх итгэлийг хүртэл Ертөнцийн Эзэн хүнд бэлэглэдэг.

Петрийн бичсэн дээрх ишлэлээс харахад Петр Паулыг их үнэлж, Ертөнцийн Эзэний мэргэн ухааныг авсан хүнд тооцов. Паулын захидлуудыг Петр Их Эзэний эрх мэдлийг тээдэг Бичвэр гэж харсан юм. Гэтэл өөрөөсөө эсрэг зүйл заадаг Паулыг Петр хэрхэн үнэлэхэд хүрсэн бэ? Иаков ч Паулыг хүлээж авсан уу? Энэ сонирхолтой асуултын хариуг бид энэ нийтлэлд хайж олох болно.



Паулыг хүлээж авахад Их Эзэн Петрийг бэлтгэсэн нь

Паул Христ Есүстэй учирсны дараахан хүнтэй зөвлөлдөөгүй, харин ганцаархнаа Арабын цөл явсан. Тэнд Их Эзэнтэй цаг өнгөрөөж, Түүний үгийг судлан байсан буй за. Гурван жилийн дараа л Паул апостолуудын ахлагч Петртэй уулзан танилцахаар Иерусалим хот руу явж, тэндхийн итгэгч нартай нийлэхийг оролдов. Гэвч тэд түүнийг жинхнээсээ итгэгч болсонд итгээгүй. Христэд итгэхээсээ өмнө Паул итгэгч нарыг нь дэндүү хэрцгийгээр хавчиж байсныг тэд мартаагүй учраас түүнээс айн болгоомжилсон (Галат 1:15-18; Үйлс 9:26; 8:3, 9:1).

Барнаб л Паулд итгээд түүнийг Петр болон бусад элч апостол нартай уулзуулж, Их Эзэн Есүс Паулд Дамаск хотод очих замд үзэгдэн үгээ хэлсэн тухай тэдэнд ярьж өгсөн. Мөн, Дамаск хотод байхдаа Паул Есүсийн нэрээр олны өмнө зоригтойгоор ярьж байсныг ч Барнаб тэдэнд ярьсан. Энэ тухай Барнаб Дамаск дахь итгэгчдээс, магадгүй Ананиас гэдэг Дамаскын дагалдагчаас сонсож байсан буй за (Үйлс 9:27).

Ананиас лав Паулын үгийн үнэнг баталж чадах хүн. Их Эзэн түүнийг үзэгдлээр дамжуулан “Шулуун” гэдэг гудамд Паулыг хайж, түүнд гар хүрч хараатай болохыг нь гуйхыг тушаав. Паултай уулзахаас айсан Ананиаст Их Эзэн Паулд үзэгдсэн тухайгаа ярьж, Паулыг үндэстнүүдийн дунд ч, израилчуудад ч онцгой үйлчлэл хийхээр дуудснаа Ананиаст тайлбарласан. Ананиас Их Эзэний үгийг дагаж, тэр гудамд үнэхээр сохорсон Паулыг олсон нь тэр үзэгдлийн үнэнг баталсан. Харин үүнээс ч



илүү, энэ явдал Паулын Их Эзэн Есүстэй хэрхэн учирч итгэгч болсон тухай үгийг ч батлав (Үйлс 9:10-17).

Барнабын ачаар Паул апостол нартай танилцан 15 хоногийн турш тэдэнтэй чөлөөтэй харьцаж байлаа.

Тэдгээрийн дундаас Паул арван хоёр элч нарын ахлагч Петрийг дурддаг бөгөөд “апостол нар ба Их Эзэний дүү Иаковоос өөр хэнтэй ч би уулзаагүй” гэжээ (Галат 1:18-19; МО; Петрийг арамай хэлээр Кеф гэдэг, Иохан 1:42-г үзнэ үү; Иаков хэзээ ч апостолоор томилогдоогүй).




Ингээд Паул Христэд итгэснийхээ дараа анх удаа Иерусалим хотод очихдоо Петр, Иаков хоёртой танилцаж, тэдэнд итгэгч мөн гэж хүлээн зөвшөөрөгдсөн. Гэхдээ “хүнээс аваагүй, хүнээр ч заалгаагүй, харин Есүс Христийн илчлэлээр хүлээж авсан”, “хүмүүний дагуу бус” онцгой сайн мэдээгээ тэр энэ удаад ярьсангүй (Галат 1:11-12).

Энэ дэлхий дээр амьдрах хугацаандаа Есүс зөвхөн Израилд илгээгдсэн байв (Матай 15:24). Тэнгэр өөд алдаршсныхаа дараа л Паулд илчилсэн зүйлсээ тэрээр энэ дэлхий дээр байхдаа огтхон ч яриагүй. Иймд Петр Паулыг хүлээж аваад зогсохгүй, онцгой сайн мэдээг нь ч хүлээн зөвшөөрүүлэхийн тулд Их Эзэн тодорхой бэлтгэл ажил хийх шаардлагатай байв.



Иймд Паулыг үндэстнүүдийн дунд үйлчлэхээр дуудсаны дараахан (Үйлс 9) Тэрээр Петрт үндэстнүүдийн итгэгчдийг хүлээн авч байхыг заахаар маш чухал үйл явдлыг зохион өрнүүлэв (Үйлс 10). Үүний тулд Их Эзэн эхлээд Ромын зуутын дарга Корнелд нэгэн тэнгэр элчийг илгээсэн. Корнел ром цэрэг ч гэсэн Ертөнцийн Эзэнийг хүндэтгэн Түүнтэй байнга ярьдаг бөгөөд иудейчүүдэд их өглөг өгдөг хүн. Ер бусын элч Петрийг дуудахыг Корнелд тушаангаа түүнийг хаанаас олохыг ч заасан.

Корнел Петрийг дуудахаар хүмүүсээ илгээсний дараа Их Эзэн Петрт нэгэн хачин үзэгдэл үзүүлсэн. Хуулиар бузард



тооцогдох олон амьтныг агуулсан бүтээлэг тэнгэрээс бууж байхыг Петр харж, “нядлаад ид!” гэж тушаасан дууг сонссон. Гэтэл идэх нь Хуулиар хоригдсон гээд Петр татгалзав. Үүнд тэр дуу

хоолой “Их Эзэний цэвэр ариун болгосон зүйлийг бузар гэж бүү нэрлэ” хэмээн тушаав. Тэр үзэгдэл нийт гурвын гурван удаа үзэгдсэн нь их чухал байсныг нь харуулна. Мөн дараагийн бүлэгт Петр тэр үзэгдлийг бусад итгэгчдэд ярьсаныг ч Лук дахин нэгд нэгэнгүй тэмдэглэснээс харахад үлэмжийн чухал болох нь мэдэгдэнэ.



Петр тэр хачин үзэгдлийн учрыг гайхан бодож байхад нь Корнелийн хүмүүс хаалгыг нь тогшив. Ариун Сүнс тэр гурван хүнийг Өөрөө илгээсэн учраас хамт яв гэж Петрт тушаав. Уг нь бусад үндэстний хүмүүс иудейчүүдийн хувьд бузарт тооцогддог бөгөөд уламжлалынх нь хатуу дүрмийн дагуу иудей хүн өөр үндэстний хүний гэрт орох хориотой. Харин Петр үзэгдлээр авсан Их Эзэний үгийг санаж, хамт явсан. Тэгэхдээ хэдэн итгэлийн ах дүүсийг хань ба гэрч болгон дагуулжээ.

Корнел хамаг гэрийнхэнтэйгээ хамт Петрийг угтан авч,

яагаад дуудсныг нь тайлбарлаад хэлэх үгийг нь анхааралтай сонссон. Тэгээд Петр тэдэнд Есүсийн тухай ярьж дуусаагүй байхад Ариун Сүнс тэр ромчууд дээр буусан. Петр анх иудейчүүдэд



сургаал заахдаа тэднийг санаагаа өөрчилж усан баптисм хийлгэх ёстой, тэгвэл Ариун Сүнсийг бэлэг болгон хүлээж авна гэж хэлсэн (Үйлс 2:38). Гэтэл иудейчүүдэд бузарт тооцогддог энэ ромчуудыг Ариун Сүнс усан баптисм хүртэхийг хүлээх ч үгүй шууд тэдний дээр буусан юм. Ариун Сүнсний бэлгийг Их Эзэн үндэстний хүмүүст өгсөнд Петр болон хань болж хамт ирсэн иудей итгэгч нар асар их гайхсан.



Энэ сонин явдлаар Петр их чухал ойлголт авлаа:
“Ертөнцийн Эзэн хүмүүсийг ялгаварладаггүй, харин
Түүнээс эмээж, зөвийг үйлдэгч ямар ч үндэстний хүн
Түүнд хүлээн зөвшөөрөгддөг гэдгийг би үнэхээр ойлгож
авлаа” гэжээ (Үйлс 10:34-35, МО).


Хэсэг хугацааны дараа Барнаб Паулыг Антиох хотын сүм
чуулганд үйлчлэхээр дуудсан (Үйлс 11:21). Тэгээд нэгэн
өдөр Ариун Сүнс Паул, Барнаб хоёрыг тусгай ажилд
дуудан “тусгаарлахад” тэд анхны илгээлтийн аянд гарчээ
(Үйлс 13:2). Тэр үед Паул анх удаа үндэстнүүдийн дунд
явж, тэдэнд Есүсийн тухай сайн мэдээг ярьсан. Тэр
аялалаас эхлэн Паул гайхамшиг үйлдэж эхэлсэн. Паултай
ч гэсэн Их Эзэн “хамт ажиллаж, дагалдах тэмдгүүдээр
үгийг баталсаар байв” (Марк 16:20). Антиох хотод буцаж
ирэхдээ тэд өөрсдөөр нь дамжин Ертөнцийн Эзэний
хийсэн бүхнийг тайлагнаж, Тэрээр үндэстний хүмүүст
зориулж “итгэлийн нэг үүдийг нээсэн” болохыг зарлав
(Үйлс 14:27).

Энэ тухай Иудей аймгаас ирсэн иудей итгэгч нар сонсоод
үндэстнүүдийн итгэгчид аврагдахын тулд хозлох (хөвч
хөндөх) зан үйлийг заавал хийлгэх ёстой гэж хэлсэн.
Гэтэл Паул, Барнаб хоёр еврейжүүлэгч энэ санааг
эсэргүүцсэн. Ингээд хозлуулах ёстой эсэх тал дээр
Антиохын чуулганд багагүй маргаан үүссэн учраас эцэст
нь Иерусалим хот явж, тэнд апостол элч нараас асууж
шийдийг нь сонсохоор болов.

Иерусалимд сүм чуулганы ахлагчид энэ асуудлаар
хуралдахад Петр босож, Их Эзэний өөрт нь харуулсан



үнэнг санаж хамгаалснаа еврейжүүлэгч нарыг мөн эсэргүүцэх үг хэлсэн. Үүнд: “Зүрх сэтгэлийг мэдэгч Ертөнцийн Эзэн Ариун Сүнийг бидэнд өгсөн шигээ тэдэнд ч мөн өгснөөр тэднийг хүлээж авснаа гэрчилсэн. Зүрх сэтгэлийг нь Тэр итгэлээр ариутгаж, бидний ба тэдний хооронд ялгаварлаагүй билээ... бид Их Эзэн Есүсийн хайр ивээлээр аврагдана гэдэгт итгэдэг бөгөөд тэд нар ч мөн



тэр л арга замаар аврагдах юм” гээд үндэстнүүдийн итгэгчдэд хозлуулах шаардлага тулгах хэрэггүй гэв (Үйлс 15:1-2,8-11; МО).

Энэ бол «Үйлс» номд тэмдэглэсэн Петрийн сүүлчийн үгс. Петр апостолуудын ахлагч боловч Есүсийн төрсөн дүү Иаков энэ хуралд эцсийн шийдийг гаргажээ. Тэрээр Петрийн үгийг сайшаан, үндэстнүүдээс Ертөнцийн Эзэн Өөртөө хүмүүсийг сонгон авахыг «Хуучин гэрээ»-нд бичигдсэн байдгийг бүгдэд сануулж, үндэстнүүдийн итгэгчдийг хозлол хийлгэх хэрэггүй гэж үг яриагаараа ч, тогтоол бичгээр ч баталсан.

Тухайн үед Паул энэ маргааныг шийдүүлэх гээд зогсохгүй Их Эзэнээс авсан “илчлэлийн дагуу” Иерусалим хотод ирсэн байв. Тэрээр энэ удаад үндэстнүүдийн дунд тунхагладаг сайн мэдээгээ сүм чуулганы ахлагч нарт хувьчлан дэлгэрүүлэн ярьж тайлбарласан (Галат 2:2).



Хэрэв Паулын тунхагладаг сайн мэдээ нь Петр, Иохан, Иаков нарын зарладаг сайн мэдээнээс ялгаагүй байсан бол ингэж тодруулан тайлбарлах шаардлага байхгүй байхсан. Энэ уулзалтын эцэст Петр, Иохан, Иаков нар “хозлуулагдсын төлөөх сайн мэдээ Петрт даалгагдсан шиг хозлуулаагүй хүмүүсийн төлөөх сайн мэдээ (Паулд) даалгагдсаныг” олж хараад “нөхөрлөлийн баруун гараа” Паул Барнаб хоёрт сунгасан. Өөрөөр хэлбэл, Паулын үндэстнүүдэд зориулсан сайн мэдээ өөр боловч тэд түүнийг итгэлийн жинхэнэ ахаар хүлээж авсан. Хэрэв Их Эзэн Петрийг урьдаас сайтар бэлдээгүй байсан бол тэд Паулын шинэ сайн мэдээг хүлээн зөвшөөрөх байсан гэж үү?

Ямартай ч “хозлуулагдсын төлөөх элч” нарын хувьд тэд өөрсдийгөө үндэстнүүд рүү биш, “хозлуулагсад рүү явах” үүрэгтэй гэдгээ ч Паулд баталж байсан (Галат 2:7-9). “Агуу захирамж”-ийг биелүүлэх цаг тухайн үед болоогүй байсныг тэд мэдсэн учраас тэр.

Петр өөрийн дуудлагадаа үнэнч үлдсэн нь

Үүнээс харахад Петр “хозлуулаагүй хүмүүсийн төлөөх сайн мэдээ”-г сонсоод Их Эзэнээс ирснийг нь хүлээн зөвшөөрсөн ч гэсэн өөртөө хүлээж аваагүй. Есүс өөрт нь аль хэдийн өөр сайн мэдээг даатгасан учраас тэр. Их Эзэний өөрт нь даатгаж өгсөн зүйлийг хүн орхих ёсгүй.

Петрийн хувь заяа зайлшгүй хозлуулагсад ба тэдэнд амласан ирээдүйн мянган жилийн хаант улстай холбогдсон. Тэр хаант улсад Израилын арван хоёр овгийн нэгийг захирах үүрэг Петрт оногджээ (Матай 19:28).



Харин тэнгэрийн дээрх улсад үйлчлэх Христийн Биед өгсөн дуудлага Петрт өгөгдөөгүй. Хүн хоёр газар зэрэг байж чадахгүй нь ойлгомжтой. Мөн, Их Эзэний дуудлага буцалтгүй учраас хэн ч дуудлагаа өөрчилж чадахгүй (Ром 11:29). Паулын хувьд мөн тийм болохыг Петр ч ойлгосон. Иймд Петр Паулыг өөрөөсөө өөр дуудлагатай ч гэсэн адилхан Их Эзэнд үйлчилдэг, итгэлийн ах мөн гэж харсан.

Паул Петрийг зэмлэхэд хүрсэн нь

Дараа нь Паул Антиох хотод буцсан байхад нь Петр цуглаанд нь зочлон ирсэн. Петр үндэстнүүдийн итгэгчтэй чөлөөтэй нөхөрлөж байсан чинь Есүсийн дүү Иаковын илгээсэн хүмүүс зочлон ирэхэд Петр тэднээс айгаад бусад үндэстнүүдийн итгэгч нараас зайгаа авав. Энэ нь “сайн мэдээний үнэн”-тэй, мөн Петрийн өмнөх үгтэй нийцээгүй учраас Паул Петрийг олны өмнө зэмлэхэд хүрсэн. Тэрээр иудей бус итгэгчдийн итгэлийг хамгаалахын тулд түүнийг “хоёр нүүр гаргаж байна” хэмээн буруутган загнажээ (Галат 2:11-14).



Апостол нарын ахлагчийн өөдөөс босож, тийм хатуу үг хэлэх нь Паулд амар байгаагүй буй за. Гэвч итгэгчид



сэтгэлээр унаж, итгэл нь нурж устгахгүйн тулд энэ арга хэмжээг авах нь шаардлагатай байв.

Петрийн хувьд ч ингэж зэмлүүлэх нь хэцүү байсан биз ээ. Гэхдээ Паулын үг яалт ч үгүй үнэн байв. Ямар ч байсан Петр дараа нь Паулын мэргэн ухааныг үнэлсэн тухайгаа бичдэг. Петр Есүст үнэхээр хайртай учраас үнэнд ч хайртай бөгөөд ялангуяа ахлагч хүн үнэний өөдөөс даруухан байх нь зөв гэж мэдсэн.

Дуулал 141:5-н үг юутай үнэн бэ:

“Зөвт нь намайг цохиг, энэрэл журам болно.

Зэмлэж намайг сургаг, шилмэл тос мэт байна.

Толгой минь үүнээс үл татгалзана.”

Энэ үгийн дагуу Петр Паулын зэмлэлийг хүртэл зөв ба мэргэн ухаантай гэж хүлээж авч чадсан. (Үүнд хугацаа шаардлагатай байсан байх. «Галат» захидлаа Паул үйлчлэлийнхээ эртний үед буюу МЭ 55-57 оны хооронд бичсэн. Харин Петр хоёрдахь захидлаа 64-67 оны хооронд бичсэн гэж судлаачид үздэг.)

Петр Паулын бичсэн захидлуудыг өөрөө уншдаг байснаас ч харахад Петр Паулыг үнэхээр үнэлдэг байсан.¹

1 Петрийн үгнээс тэгэж ойлгогдож байгаагаас гадна тэрээр Паулын зарим үг хэллэгийг өөрөө хэрэглэн, зарим сэдвийг нь авч давтан бичсэн. Тухайлбал:

--“Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан магтагдах болтугай” (Эфэс 1:3 – 1 Петр 1:3);

--буруу зан, муухай яриа “бүгдийг хая” (Колоссай 3:8 – 1 Петр 2:1);

--“эхнэрүүд ээ, нөхрүүддээ захирагд” (Эфэс 5:22 – 1 Петр 3:1);

--“нэг нэгэндээ захирагд” (Эфэс 5:21 – 1 Петр 5:5);

--“сэргэг бөгөөд эрүүл ухаантай” бай (1 Тесалоник 5:6 – 1 Петр 5:8);

--“үнсэлтээр нэг нэгэндээ мэнд хүргэ” (1 Коринт 16:20 – 1 Петр 5:14);



Еврейчүүдэд бичсэн Петр ба Паулын захидлууд

Петр өөрийн захидлаа иудейчүүдэд бичсэн, нарийвчлан хэлэхэд Израил нутгийн гадаах, олон үндэстний дунд тархсан еврейчүүдэд зориулж бичсэн. “Хозлуулагсдын төлөөх элч”-ийн хувьд Петр үндэстнүүд рүү биш, “хозлуулагсад рүү явах” үүрэгтэй учраас тэр (Галат 2:7-9).

Тэгвэл Петр Паулыг Их Эзэний тэвчээрийн тухай “та нарт” бичсэн гэхэд «Еврейчүүдэд» гэдэг захидлыг ярьж байгаа нь ойлгогдож байна (2 Петр 3:15). “Хаант улс ойрхон байна” гэсэн сайн мэдээг МЭ 30-аад оны үед сонсоод итгэсэн иудейчүүд жил өнгөрөх тусам, ойрхон байсан Хаант улс яагаад ирэхгүй байгаад цөхөрч шантарч байв. Тэднийг итгэлээсээ ухрахгүй байж, Их Эзэний

--энэ цаг үеийн зовлонгууд ба ирээдүйд илчлэгдэх алдар (Ром 8:18 – 1 Петр 5:1);

--Есүсийг үхэгсдээс амилуулсан Ертөнцийн Эзэнд итгэж буй хүмүүс (Ром 4:24 – 1 Петр 1:21);

--эрх мэдлүүд Их Эзэнээр томилогдсон учраас тэдэнд захирагд (Ром 13:1,3-4 – 1 Петр 2:13-14);

--эмэгтэй хүний үнэн чимэг гаднах зүйлс биш (1 Тимот 2:9 – 1 Петр 3:3);

--итгэгч эмэгтэйчүүд найдвараа Ертөнцийн Эзэнд тавьсан (1 Тимот 5:5 – 1 Петр 3:5).

Эдгээр жишээнээс харахад Петр Паулын гол сургаалыг өөрийн болгоогүй ч гэсэн бичсэн олон ерөнхий зүйлтэй нь санаа нэгдсэн. Судлаачдийн үзлээр Петр эхний захидлаа МЭ 60-65 оны хооронд, хоёрдахь захидлаа 64-67 оны хооронд бичсэн. Паул «Эфэс», «Холоссай» хэмээх захидлуудаа МЭ 60-61 оны хооронд бичсэн бол дээр дурдсан бусад захидлаа тэрнээс өмнө бичив. Тэгэхээр Петрт түүний захидлуудыг унших хугацаа байсан.



амалсныг тэвчээртэй хүлээх зориг оруулах гэж Паул тэдэнд «Еврейчүүдэд» хэмээх захидлыг бичив. Паулын үйлчлэл зөвхөн үндэстнүүдээр хязгаарлагдаагүй, Их Эзэн түүнийг бас “Израилын хөвгүүдэд” (өөрөөр хэлбэл үндэстнүүдийн дунд амьдарч буй израилын хүмүүст) Өөрийнх нь тухай ярих үүрэг өгсөн билээ (Үйлс 9:15). Петр Паулыг хамтран ажиллагчийн хувьд ч үнэлсэн нь дээрх үгнээс нь харагдаж байна.

Харамсалтай нь, Паултай уулзаж үзээгүй, энгийн иудей итгэгч нарт бусад захиандаа бичсэн олон зүйл нь ойлгомжгүй байлаа. Паултай хэд хэдэн хоног хувьчлан цаг өнгөрөөсөн Петрт хүртэл түүний ярьсан, бичсэн зарим зүйлс ойлгоход бэрх байсан нь дээрх ишлэлээс ил.

Паулын зарладаг

сайн мэдээ

үндэстнүүдэд

зориулсан

болохоос

иудейчүүдэд

зориулаагүй

учраас тэр. Иймд

тэдний олонхи нь

Паулыг үнэлээгүй

бүү хэл,

“Мосегийн Хуулийг эсэргүүцдэг” гэж түүнийг дүгнээд үндэстнүүдэд Христийн тухай ярьсных нь төлөө хавчдаг, мөн алахыг ч оролдсон (Үйлс 21:20-22, 28-31; 22:21-22).

Ахлагч апостол Петрийнхээ үндэстнүүд ба Паулын тухай хэлсэн үгийг, Иаков ч Паулыг ахын ёсоор хүлээж авсныг тэд ойшоогүй нь үнэн харамсалтай.





Ямартай ч, Паул энэ шалтгаанаар «Еврейчүүдэд» гэдэг захидалд нэрээ бичээгүй нь тэр биз ээ. Нэрээ тавьсан бол ихэнх нь захидлыг нь уншихгүй, ураад шатаах байсан буй за.²

Гэхдээ учирлах стил нь яг л Паулынх шиг, «Хуучин гэрээ»-г мэддэг зохиолчийн мэдлэг нь судлаач хүнийх. Паулын итгэлийн хүү Тимот ч эцэст нь дурдагдсан зэрэг зохиолчийг нь заадаг олон сэжүүр бий. Ямартай ч тэр захидал хэн бичснийг Петр мэдэж байсан нь лавтай.

Дүгнэж хэлэхэд, Их Эзэн Хаант улсынхаа түлхүүр өгсөн апостол Петрийг хэрхэн өөрийн зарладаг сайн мэдээнээс эрс өөр сайн мэдээг тунхагладаг Паулыг хүлээн зөвшөөрөн дэмжихэд хүргэсэн үйл явц үнэхээр өвөрмөц. Паулын сайн мэдээ нь тэнгэрийн хаанчлалын сайн мэдээнээс огт өөр боловч адил Их Эзэнээс ирсэн нь Петр ба Иаков нарын хувьд лав бүрэн батлагдсан юм. □

Дараагийн нийтлэлд бид Петрийн хувьд ойлгоход хэцүү, Паулын бичсэн нэгэн нууцлаг ишлэлийг тайлна. Энэ нь хоёр сайн мэдээний дундах үндсэн ялгааг дахин нэг харуулна.

2 Паул нэрээ «Еврейчүүдэд» захидалд бичээгүй бас нэг шалтгаан бий. Үүнд: Паулын нэрээр тэмдэглэсэн бүх захидал өөрт нь даатгасан, үндэстнүүдэд зориулсан сайн мэдээг агуулна. Хамаг Библи бидний төлөө бичигдсэн ч гэсэн, бүх үг нь бидэнд хандаагүй. «Еврейчүүдэд» бичсэн үгийг бид уншиж, олон зүйлийг ойлгож авч болох ч заавар тушаал, амлалт анхааруулгыг нь өөртөө наалдуулах хэрэггүй гэсэн үг. Еврей бус үндэстний хүн бидэнд хандаж бичсэн бичвэрүүд бүгд Паулын нэрээр тэмдэглээстэй учраас ялгаж олоход амар.



Ашигласан эх сурвалж:

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичвэр Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Barnes, A. (1870). *Albert Barnes' Notes on the Bible*. As found in the [MySword Bible study software program](#)

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Gill, J. (1746248). *An Exposition of the New Testament*.

<https://www.christianity.com/bible/commentary/john-gill/>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). *Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons)*. www.blueletterbible.org